

Ус түгээх цэгийн 20... оны судалгааны маягт (ЭАБ-8) - ыг нөхөх заавар

Дүүргийн ЗДТГ нь нутаг дэвсгэртээ байгаа ус түгээх цэгийн судалгааг маягтын дагуу нэгтгэн гаргана.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил: Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

1 дүгээр баганад: Ус түгээх цэгийн тоог нөхнө. Ус түгээх цэгт стандартын шаардлага хангасан ундны усаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх цэгийг хамруулна. 1 дүгээр баганын дүн нь 2-4 дүгээр баганын дүнтэй тэнцүү байна.

2-3 дугаар баганад стандартын шаардлага хангасан ус түгээх цэгийн тоог нөхнө.

2 дугаар баганад: Төвлөрсөн сүлжээнд холбогдсон ус түгээх цэгийн тоог нөхнө. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ус түгээх цэгт төвлөрсөн цэвэр усны эх үүсвэрээс инженерийн нэгдсэн шугам сүлжээгээр дамжиж усаа цэнэглэдэг ус түгээх цэгийг хамруулна.

3 дугаар баганад: Баталгаат эх үүсвэрээс цэнэглэдэг ус түгээх цэгийн тоог бичнэ. Баталгаат эх үүсвэрээс цэнэглэдэг ус түгээх цэгт "Ус сүвгийн удирдах газар"-ын баталгаат усны эх үүсвэр худгаас зориулалтын авто машинаар ус авдаг ус түгээх цэгийг хамруулна.

4 дүгээр баганад: Баталгаат бус эх үүсвэрээс цэнэглэдэг ус түгээх цэгийн тоог нөхнө. Баталгаат бус эх үүсвэрээр усаа авч цэнэглэдэг ус түгээх цэгт дээрхээс бусад нөхцөлөөр усаа цэнэглэдэг ус түгээх цэгийг хамруулна.